



ЕБС-ИЙН ЗАХИРАЛ



П.Очирпүрэв

**ХАТАНБУЛАГ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр

**Төслийн нэр: ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН “ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН
ХООЛ ХҮНС НИЙЛҮҮЛЭХ” ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

Төслийн дугаар: ДГАХБСЕБС/202208001

Хатанбулаг сум

2024 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер зарлах огноо: 2024.2.29

Хатанбулаг сумын ЕБС нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Дотуур байрны хүүхдийн хоол хүнс” нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны стандарт, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2024 оны 03 дугаар сарын 11 -ны өдрийн 15 цаг 00 минутаас** өмнө **Хатанбулаг сумын ЕБС-ийн Англи хэлний багш Э.Гантөгс** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024 оны 03 дугаар сарын 11 -ны өдрийн 15 цаг 30 минутад** нээнэ.

Тендерийн баримт бичгийн үнэ болох 50.000 төгрөгийг Төрийн сан банк 100061015401 ЕБС-ийн нэмэлт санхүүжилт гэсэн дансанд тушаан тендерийн баримт бичиг авна.

Хатанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль
Утас 88911500
Имейл: purewdorjochirpurew@gmail.com

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Оролцогч компанийн танилцуулга
(в) Бараа нийлүүлэх хуваарь;
(г) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
(д) Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар;
(е) Шаардлагатай тусгай зөвшөөрөл “Хүнсний бүтээгдэхүүн худалдаалах, нийлүүлэх”
(ё) -Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар
-Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар

-Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл

-Харъяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

- Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх

-Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл нэг жилээр
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан байх /дэвтрийн хуулбар/

- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт ариутгал, халдваргүйтгэл хийлгэсэн байх |

- | | |
|--|--|
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ-д</i> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <i>хүнсний бүтээгдэхүүн худалдаалах тусгай зөвшөөрөлтэй</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сум 5-р баг ЕБС</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Хатанбулаг сумын ЕБС-ийн 2 давхарт 205 тоот өрөө</i></p> <p>Огноо: <i>2024 оны 03 дугаар сарын 11 -ны өдөр</i></p> <p>Цаг: <i>15 цаг 00 минут</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Хатанбулаг сум 5-р баг ЕБС</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Хатанбулаг сумын ЕБС-ийн 1 давхарт 102 тоот өрөө</i></p> <p>Огноо: <i>2024 оны 03 дугаар сарын 11 -ны өдөр</i></p> <p>Цаг: <i>15 цаг 30 минут</i></p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хүнс нийлүүлэх <i>ДГАХБСЕБС/202208001</i></p>

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 9. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
- 9.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 10. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 6.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 6.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 11. Тендерийн иж бүрдэл**
- 7.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) Үнийн санал;
 - (б) Оролцогч компанийн танилцуулга
 - (в) Бараа нийлүүлэх хуваарь;
 - (г) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (д) Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар;
 - (е) Шаардлагатай тусгай зөвшөөрөл “Хоол үйлдвэрлэх, үйлчилгээ явуулах”
 - (ё) Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан байх /дэвтрийн хуулбар/
 - (з) Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган зориулалтын үйлдвэрлэх, хадгалах, зөөвөрлөх, тоног төхөөрөмжтэй байх /фото зураг/
 - (ж) Гэрээг гүйцэтгэгч голлох боловсон хүчний ур чадвар, мэргэжил, мэргэшлийн гэрчилгээ /баталгаажсан хуулбар/
 - (и) Үдийн цайнд нийлүүлэх хоол болон хүнсний бүтээгдэхүүний танилцуулга /4 долоо хоногийн цэс байдлаар/
 - (к) Цэсэнд байх нийт бүтээгдэхүүний жагсаалт, технологийн карт
 - (л) Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт ариутгал, халдваргүйтгэл хийлгэсэн байх
- 12. Тогтмол үнэ**
- 12.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

- 13. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 13.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 13.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 14. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 14.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 15. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 15.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 15.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь *ТШӨХ*-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 15.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 16. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 16.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

<p>ТӨӨЗ-ны холбогдох заалт</p>	<p>Шалгуур үзүүлэлт</p>
---------------------------------------	--------------------------------

<p>ТӨӨЗ 1.1</p>	<p>Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <i>хүнсний бүтээгдэхүүн худалдаалах тусгай зөвшөөрөлтэй</i></p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хатанбулаг сум 5-р баг ЕБС</p> <p>Давхар болон ерөөний дугаар: Хатанбулаг сумын ЕБС-ийн 2 давхарт 205 тоот өрөө</p> <p>Огноо: 2024 оны 03 дугаар сарын 11-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 05 минут</p>
<p>ТӨӨЗ 2.1</p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хатанбулаг сум 5-р баг ЕБС</p> <p>Давхар болон ерөөний дугаар: Хатанбулаг сумын ЕБС-ийн 2 давхарт 205 тоот өрөө</p> <p>Огноо:2024 оны 03 дугаар сарын 11-ны өдөр</p> <p>Цаг: 15 цаг 35 минут</p>
<p>ТӨӨЗ 6.2</p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хүнс нийлүүлэх ЕБС-НТШ-2021/01</p>

Хатанбулаг сумын ЕБС-ийн “Үдийн хоол хөтөлбөрийн хоол хүнс” нийлүүлэх ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгавар.

1. Дараах жагсаалтын дагуу стандартын шаардлага хангасан органик, шим тэжээллэг, стратегийн хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлнэ.

ХАТАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСЭНД ШААРДЛАГАТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН

2024 он

Д/Д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тавигдах шаардлага
1	Гурил \дээд\	кг	2000	Дотоодын үйлдвэрийн дээд гурил байх ба Улаанбаатар эсхүл түүнтэй дүйцэх
2	Цагаан будаа	кг	1000	Дээд зэргийн цагаан будаа
3	Шар будаа	кг	140	Чанарын шаардлага хангасан байх ба “Слава” эсхүл түүнтэй дүйцэхүйц байна.
4	Гурвалжин будаа	кг	100	
5	Каш	ш	50	
6	Сахар	кг	270	
7	Сүү	ш	290	Монгол сүү буюу үнээний, ингэний сүү, сүүн бүтээгдэхүүн байна. Мал эмнэлгийн зөвшөөрлийн бичигтэй байх
8	Цагаа	л	200	
9	Гоймон \мушгаа\	кг	250	Ус даах чадвартай \ шалбардаггүй\
10	Гоймон /туузан/	ш	240	Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн байх ба лапша эсхүл түүнтэй дүйцэх
11	Давс	ш	150	Нуурын бор давс болон иоджуулсан цагаан давс байж болно.
12	Ургамлын тос		300	100% байгалийн гаралтай наран цэцгийн тос
13	Төмс	кг	1800	Дотоодын буюу монголд тарьж ургуулсан байх ба шинэ ургацын ногоог 7 хоногоор нөөцлөнө.
14	Байцай	кг	2000	
15	Лууван	кг	250	
16	Сонгино	кг	150	
17	Манжин	кг	200	
18	Шөлний байцай	ш	130	Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн байна.
19	Үзэм	кг	40	Шороо, чулуугүй цэвэр байх
20	Чацаргана	кг	300	Байгалийн цэвэр \зэрлэг жимс\ жимсийг 14 хоногоор нөөцлөх ба цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан байхгүй тохиолдолд хатаасан жимс авна.

21	Масло	кг	150	Дотоодын үйлдвэрийн 100% байгалийн гаралтай бүтээгдэхүүн байх
22	Үхрийн мах	кг	1200	Шинжилгээний бичигтэй 1-р зэргийн мах байх ба үхэр, хонины цул мах байна. Ястай махыг ясны хорогдлыг тооцож хямд үнээр авна.
23	Хонины мах	кг	1200	
24	Эсгэгч		100	Чанарын шаардлага хангасан байх
25	Хуурай цай	ш	90	Дотоодын үйлдвэрийн хуурай цай

2. Хүнс нийлүүлэхдээ дараах хугацааг баримтлана.

- Махыг улирлын онцлогоос шалтгаалан 7-21 хоногоор нийлүүлэх
- Гурил, будаа, гоймон, сахар зэргийг 14 хоногоор нийлүүлэх
- Хүнсний ногоог 7 хоног тутам шинэ ногоо нийлүүлэх
- Сүү, сүүн бүтээгдэхүүнийг 7 хоногоор нийлүүлэх
- Жимс, жимсгэнийг 14 хоногоор нийлүүлэх

3. Орлуулан авах буюу нэмэлт хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжтой эсэхээ баталгаажуулж дараах жагсаалтын дагуу нэгжийн үнийг ирүүлнэ.

№	Хүнсний бүтээгдэхүүн	Орлуулах бүтээгдэхүүн
1	Хүнсний ногоо	Ногоон огурцы
		Амтат чинжүү
		Улаан лооль
		Броккли
		Хүрэн манжин
		Шар манжин
		Сармис
		Ногоон сонгино
		Хар мөөг
		Алаг салат
		Лечо
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Хуурай сүү
		Тараг
		Зөөхий

		Аарц
		Үйлдвэрийн савлагаатай /шингэн/ сүү
3	Будаа	Эрдэнэ шишийн будаа
		Хөц будаа
		Жимстэй каш
4	Гурил	Олон үрийн гурил
5	Жимс	Чангаанз
		Хар чавга

2. Нийтлэг шаардлага

- Хадгалах хугацаа дуусаагүй, шинэ бүтээгдэхүүн
- Үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж аль болох дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх
- Хүнсний бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаадлага хангасан, шинжилгээний бичигтэй байх
- Орлуулах бүтээгдэхүүнийг шаардлагатай тохиолдолд авах бөгөөд нийлүүлэгч худалдан борлуулдаг байх
- Нийлүүлэгч нь “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай” болон бусад холбогдох хууль тогтоомжийг судалсан байх

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА

НАРИЙН БИЧИГ

ГИШҮҮД

Э.ГАНТӨГС

Н.БАЯРЧИМЭГ

Б.ЭРДЭНЭБАЯР

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [3] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>тухайн сардаа багтаан сарын сүүлийн 10</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

<p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p>	<p>1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]</p>
<p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p>	<p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p>
<p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p>	<p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p>
<p>4. Төлбөр (ГЕН – 7)</p>	<p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>
<p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹</p>	<p>9.1. Алданги оногдуулах хувь: [0.5%]</p> <p>Алдангийн нийт дүн: [10%]</p>